

БАТЛАВ. МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 1. Аудитын нэр

Хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, зах зээлийг бусад эдийн засагтай харьцуулах

### 2. Аудитын код

ҮАГ-НАГ/2014-01- ДШ

### 3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны захиалгаар Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

### 4. Аудитын зорилго

Хүнс, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийг бусад бараа бүтээгдэхүүний үнэтэй харьцуулсан дүгнэлтийг гаргахад аудитын зорилго чиглэгдэнэ. Үүнд:

1. Хэрэглээний үнийн индексээр тооцсон инфляцийн өсөлтийн чиг хандлага, бусад улс орнуудтай зэрэгцүүлсэн байдал,
2. Суурь үнийн инфляцийн өсөлт,
3. Инфляцад нөлөөлсөн гол хүчин зүйлийн шинжилгээ, үүнээс валютын ханшны инфляцад үзүүлсэн нөлөөлөл,
4. Үнийн өсөлтийг бууруулах талаар төр, засгийн зүгээс сүүлийн 3 жилд гарсан тогтоол шийдвэр, түүний хэрэгжилт,
5. Үнийг тогтворжуулах талаар Монгол банк, Засгийн газраас авсан арга хэмжээ, түүний үр дүн,
6. Хүнс, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийг бусад бараа бүтээгдэхүүний үнэтэй харьцуулсан судалгаа,
7. Эдийн засаг, банк, даатгалын чиглэлээр судалгаа шинжилгээний байгууллагуудын судлагааг авч үзэх.
8. Бусад улс орнуудад үнийг тогтворжуулах талаар авдаг арга хэмжээ, туршлага зэргийг судлаж, дүгнэлт, зөвлөмж гаргана.


### 5. Аудитын хамрах хүрээ

Аудитаар Монгол банк, Үндэсний Статистикийн Хороо, Сангийн яам, ЭЗХЯам, эдийн засаг, банк, даатгалын чиглэлээр судалгаа шинжилгээний байгууллагуудын холбогдох материалд тулгуурлан гүйцэтгэнэ.

## 6. Үндсэн мэдээлэл

Манай орны хувьд сүүлийн 3 жилд хүнс, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ өсөж, инфляцийн түвшин өндөр хурдацтай нэмэгдэж, тэр хэмжээгээрээ хүн амын амьжиргааны түвшинд сөрөг нөлөөлөх болсон. Төрөөс инфляцыг хяналтандаа байлгах, үнийн өсөлтийг тогтворжуулах чиглэлээр багагүй арга хэмжээг авсаар ирсэн боловч сүүлийн жил гадаад валютын ханш чангарч, төгрөгийн ханш огцом суларч, импортын бараа, бүтээгдэхүүнээр дамжин дотоодын үнэд хүчтэй нөлөөлөх болсон нь байдлыг улам хүндрүүлсэн байна. Иймд улс орны макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулсан энэ үзэгдлийг тал бүрээс нь судлах хэрэгцээ шаардлагыг бий болгосон байна. Үндэсний статистикийн хорооноос гаргасан макро эдийн засгийн үзүүлэлтийг танилцуулбал:

### Инфляцийн түвшин 14.9 (%) 2014 оны 7-р сарын байдлаар



	2013 I-VII	2014 I-VII	2013 I-VII 2012 I-VII	2014 I-VII 2013 I-VII
--	------------	------------	--------------------------	--------------------------

#### II. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлтүүд

Хэрэглээний үнийн улсын индексийн өөрчлөлт, жилийн эцэст, хувиар	4.9	7.2	-	-
Мөнгө M2* 7 дугаар сарын эцэст, тэрбум төг	8 088.7	10 081.0	117.5	124.6
Валютын зах зээлийн нэрлэсэн ханш, 7 дугаар сарын дундаж, 1 ам.доллар=төгрөг*	1 474.1	1 844.1	109.7	125.1
Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл, тэрбум төг	- 145.6	- 160.9	-	110.5
Улсын нэгдсэн төсвийн урсгал орлого, тэрбум төг	3 039.5	3 304.2	111.1	108.7

Улсын нэгдсэн төсвийн урсгал зарлага, тэрбум төг	2 531.3	2 921.8	97.9	115.4
Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн урсгал тэнцэл, тэрбум төг	508.2	382.3	341.8	75.2
Экспорт, сая ам.долл	2 353.6	2 940.5	92.7	124.9
Импорт, сая ам.долл	3 685.0	3 148.1	92.9	85.4
Гадаад худалдааны тэнцэл, сая ам.долл	- 1 331.4	- 207.6	93.1	15.6



## ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хүн амын амьжиргаа


Нэг өрхийн сарын дундаж орлого, жил бүрийн 2 дугаар улирлын байдлаар				Нэг өрхийн сарын дундаж зарлага, жил бүрийн 2 дугаар улирлын байдлаар			
Орлогын төрөл	2013 IV-VI	2014 IV-VI	2014 IV-VI 2013 IV-VI %	Зарлагын төрөл	2013 IV-VI	2014 IV-VI	2014 IV-VI 2013 IV-VI %
Орлого - Бүгд	940 504	1 013 956	107.8	Зарлага - Бүгд	871 547	1 010 138	115.9
1. Мөнгөн орлого - Бүгд	841 193	924 138	109.9	1. Мөнгөн зарлага - Бүгд	772 236	920 320	119.2
Цалин хөлс	419 466	490 084	116.8	Хүнсний бүтээгдэхүүний зарлага	208 012	217 594	104.6
Тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговор	149 646	141 912	94.8	Үүнээс:			
Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого	65 860	85 177	129.1	Мах, махан бүтээгдэхүүн	79 189	76 653	96.8
Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	117 146	117 439	100.3	Гурил, гурилан бүтээгдэхүүн	48 216	54 073	112.1
Бусад орлого	88 975	89 526	100.6	Хүнсний бус бараа, үйлчилгээний болон бусад зарлага	544 248	681 135	125.2
2. Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн	34 484	36 664	106.3	Үүнээс:			
3. Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн	64 827	53 154	82.0	Тээвэр	72 064	74 548	103.4
				Холбоо	32 479	35 600	109.6
				Бусдад өгсөн бэлэг, тусламж	19 976	21 591	108.1
				2. Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн	34 484	36 664	106.3
				3. Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн	64 827	53 154	82.0





**МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Үндэсний тооцоо**

**ДНБ-ий өсөлт, хувиар**  
(Үйлдвэрлэлийн аргаар, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, өмнөх оны мөн үеийнхээс)



**ДНБ-ий бүтэц, хувиар**  
(Үндэсний ашиглалтын аргаар, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, оны үнээр)



\* Урьдчилсан гүйцэтгэл

Эх сурвалж: УТЗ-ийн мэдээлэл




**МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Гадаад худалдаа**

Гадаад худалдааны үндсэн үзүүлэлт

	2013 I-VII		2014 I-VII	
	сая ам.долл	Нийт эргэлтэд эзлэх хувь	сая ам.долл	Нийт эргэлтэд эзлэх хувь
Нийт эргэлт	6 038.7	100.0	6 088.6	100.0
Экспорт	2 353.6	39.0	2 940.5	48.3
Импорт	3 685.0	61.0	3 148.1	51.7
Тэнцэл	-1 331.4	-22.0	-207.6	-3.4

Гадаад худалдааны тэнцэл, 2014 оны эхний 7 сард, улсаар



Бүтэц, барааны бүлгээр

	Экспорт		Импорт	
	2013 I-VII	2014 I-VII	2013 I-VII	2014 I-VII
Эрдэс бүтээгдэхүүн	78.5	82.8	25.2	27.1
Үнэт чулуу, гоёлын зүйлс	8.3	4.5	-	0.1
Нэхмэл бүтээгдэхүүн	9.4	8.7	0.9	1.2
Үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүн	0.5	0.4	8.0	10.2
Машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн сэлбэг, эд анги	0.8	0.7	22.1	19.2
Авто, агаарын замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги	0.5	1.0	20.5	13.7

Экспортолсон зарим эрдэс бүтээгдэхүүн, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, мян.т

	2012 I-VII	2013 I-VII	2014 I-VII
	Нүүрс	11 203.8	8 260.3
Зэсийн баяжмал	330.1	332.2	703.9
Төмрийн хүдэр	3 651.8	3 581.9	3 072.1
Боловсруулаагүй газрын тос, мян.барр	1 802.5	2 595.3	3 780.5
Цайрын хүдэр, баяжмал	66.7	80.0	53.2
Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт,т	1.2	4.7	3.2

Эх сурвалж: УТЗ-ийн мэдээлэл



БӨӨНИЙ БОЛОН ЖИЖИГЛЭН ХУДАЛДААНЫ НИЙТ БОРЛУУЛАЛТ, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, тэрбум төг



БӨӨНИЙ БОЛОН ЖИЖИГЛЭН ХУДАЛДААНЫ НИЙТ БОРЛУУЛАЛТ, дэд салбараар, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, тэрбум төг

Дэд салбар	2012 I-VI	2013 I-VI	2014 I-VI	2014 I-VI 2013 I-VI %
Бүгд	3 584.6	3 956.3	4 363.7	110.3
Бөөний худалдаа	2 241.8	2 311.9	2 654.4	114.8
Жижиглэн худалдаа	1 342.7	1 644.4	1 709.3	103.9

## 9. Аудитын арга зүй

Аудитын явцад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын арга зүйг ашиглан, аудитын хөтөлбөрийн дагуу аудитын горимоор нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

## 10. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилтод үндэслэн **Үндэсний статистикийн хорооноос авах мэдээлэл:**

1. Сүүлийн 3 жилийн хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд орсон бүх нэр төрлийн бараа үйлчилгээний сар бүрийн үнийн мэдээ,
2. 2012 оноос ашиглаж эхэлсэн хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд орсон бүх нэрийн бараа, үйлчилгээ бүрийн эзлэх хувийн жин,
3. Хэрэглээний үнийн индекс тооцдог бүх нэр төрлийн бараа, үйлчилгээний үнийн мэдээлэл цуглуулдаг дэлгэрэнгүй задаргаа,
4. Аймгуудын хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд орсон бүх бараа үйлчилгээний сүүлийн 3 жилийн үнийн мэдээлэл.
5. Аймгуудын үнийн индекс тооцдог жин,
6. Барилгын гол нэрийн материалын болон орон сууцны үнийн сүүлийн 3 жилийн сар бүрийн мэдээлэл,
7. Сүүлийн 3 жилийн ДНБ-ны дефлятор,
8. Хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний сүүлийн 3 жилийн үнийн мэдээлэл,
9. Хүнсний болон өргөн хэрэглээний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийт эрэлтийн талаарх мэдээлэл (нөөц ашиглалтын хүснэгтэн мэдээлэл) Үүнээс: Хүн амын хэрэглээ, улсын байгууллагын хэрэглээ, олон нийтийн байгууллагын хэрэглээ г.м

10. Хүнсний болон өргөн хэрэглээний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийт нийлүүлэлтийн талаарх мэдээлэл (нөөц ашиглалтын хүснэгтийн мэдээлэл)  
Үүнээс: дотоодын үйлдвэрлэл, импортын талаар.

#### Монгол банкнаас авах мэдээлэл:

1. Монгол банк, Засгийн газрын хамтран хэрэгжүүлсэн үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд авсан арга хэмжээ, зарцуулсан хөрөнгө, гарсан гол үр дүнгийн талаарх мэдээлэл,
2. Зарцуулсан хөрөнгийг арга хэмжээ тус бүрээр, зориулалтаар нь харуулсан тоон мэдээлэл,
3. Сүүлийн 3 жилийн суурь инфляцийн сар бүрийн тооцоо,
4. Монгол банкнаас сүүлийн 3 жилд инфляцийг тогтворжуулах талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн,
5. Төрийн мөнгөний бодлогын сүүлийн 3 жилийн тойм,
6. Үнийн өсөлтийг бууруулах талаар ЗГ-аас сүүлийн 3 жилд гаргасан тогтоол шийдвэрүүд.

#### 11. Аудитын хугацаа

Аудитыг 2014 оны 9 дүгээр сарын 10-нд эхэлж, 11 дугаар сарын 15-нд дуусгана.

#### 12. Аудит хийх багийн бүрэлдэхүүн


Аудитыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга Б. Алтанзул, аудитын менежер З. Ариунзаяа нар хянан удирдаж, тус газрын шинжээч Б. Билэгт, эдийн засгийн судалгааны шинжээч, судлаачдаас бүрдсэн баг гүйцэтгэнэ.

#### 13. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц

- а. Боловсон хүчин: 8 хүн - 60 хүн/өдөр
- б. Санхүүгийн нөөц: 6000.0 мян/төг
  - Судлагааны зардал
  - Бусад /бичиг хэрэг/
- в. Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, видео камер, фото аппарат болон бусад техник хэрэгсэл

Аудитын төлөвлөгөөг  
Хянаж зөвшөөрсөн:

ДЭД ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТТУЯА

Боловсруулсан:  
НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА



Б.АЛТАНЗУЛ

НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН МЕНЕЖЕР



З. АРИУНЗАЯА

2014 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр